# АЛБАН ХААГЧДЫН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ 2022 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2022.12.07

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Төсөв /сая төг/ | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас зохион байгуулах зөвлөгөөн, сургалт** | | | | | | | |
| 1 | Салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд оролцох | Зөвлөгөөнд хамрагдсан албан хаагчдын тоо | 16 | 3 | - | Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албаны дарга нарын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлж дүгнэх, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан.<br>Тус байгууллагын дарга Э.Чагнаадорж “Шилдэг менежер”-ээр, 2021 оны “Шилдэг мэргэжилтэн”-ээр Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Батцэцэг, “Шилдэг Газрын даамал”-аар Эрдэнэдалай сумын Газрын даамал Э.Ууганцэцэг нар шалгарч удирдах ажилтны зөвлөгөөнд оролцсон ба бусад албан хаагчид цахимаар оролцсон.<br>Мөн Барилгын хөгжлийн төвөөс аймгуудын ГХБХБГ-ын дарга нартай байгуулсан 2021 оны гэрээг дүгнэж 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах зөвлөгөөнийг 2022 оны 02 дугаар сард зохион байгуулсан ба уг зөвлөгөөнд тус байгууллагын дарга Э.Чагнаадорж, Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга Э.Энхмэнд нар оролцсон. | 100 |
| 2 | Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн | Хамрагдсан албан | - | 2 | - | Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас зохион байгуулсан Удирдлагын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тухай хууль тогтоомжийн хэрэгжилт | хаагчдын тоо | | | | академийн “Төрийн захиргааны удирдлага ба гүйцэтгэлийн төлөвлөлт” сэдэвт 16 цагийн кредиттэй сургалтад тус байгууллагын Газрын удирдлагын хэлтсийн дарга Б.Рэнцэндорж, Газрын төлбөр, татвар, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Болорчимэг нар хамрагдсан. Мөн “Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийг чадавхижуулах нь” сэдэвт 20 цагийн сургалтад мэрэгжилтэн Б.Солонго цахимаар хамрагдсан. | |
| 3 | Геопорталын хэрэглээ | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 2 | - | Агентлагаас 21 аймгийн ГХБХБГ-ын холбогдох албан хаагчдад “Геопортал” цахим системийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, мэдээлэл бүрдүүлэх, боловсруулах, системийн хэвийн үйл ажиллагааг хангах, орон зайн өгөгдөл мэдээллийг шинэчлэх сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулсан ба уг сургалтад Геодезийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ж.Элбэгзаяа, Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Солонго нар хамрагдсан. | 100 |
| 4 | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн хэрэглээ | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 1 | - | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн хэрэглээ, “Мэдээллийн аюулгүй байдал, домэйн” сэдэвт сургалтыг Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас 21 аймгийн ГХБХБГ-ын Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд 2022 оны 03 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулсан ба уг сургалтад Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Солонго хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Хот байгуулалтын кадастрын цахим системийн хэрэглээ | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 1 | - | Хот байгуулалтын кадастрын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт, үйл ажиллагаандаа хэрхэн ашиглах сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр цахимаар зохион байгуулсан ба уг сургалтад Хот байгуулалтын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Буманбаатар хамрагдсан. | 100 |
| 6 | Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудыг чадавхижуулах | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 1 | - | 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр ГЗБГЗЗГ-аас зохион байгуулсан аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудыг чадавхжуулах сургалтад хамрагдаж 1 багц цагийн гэрчилгээ авсан. 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төвөөс зохион байгуулсан “Архитектурын өвийг хадгалж хамгаалах нь” сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан. | 100 |
| 7 | “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-ийн хэрэглээ *Мэргэжлийн программ хангамж /QGIS, ArcGis, AutoCad/-ийн шинэ хэрэгжүүлж байгаа бусад программийн чадавхижуулах/* | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 1 | - | “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системын хэрэглээ, хөгжүүлэлт” сэдэвт сургалтыг Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас 2022 оны 04 дүгээр сарын 7-8 ны өдрүүдэд зохион байгуулсан ба уг сургалтад газар зохион байгуулалт, төлөвлөлт газар өмчлөл хариуцсан ахла мэргэжилтэн Т.Саранзул хамрагдсан. | 100 |
| 8 | “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д хот байгуулалтын баримт бичгийг оруулах аргачлал | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 1 | - | “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системын хэрэглээ” сэдэвт дадлагажуулах цахим сургалтыг Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан ба уг сургалтад шинээр томилогдсон 7 сумын Газрын даамал хамрагдсан. | 100 |
| 9 | Хот төлөвлөлтийн чиглэлээр шинээр | Сургалтад хамрагдсан албан | - | 1 | - | 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр БХБЯ-аас зохион байгуулсан “Сумын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон шинэчлэн батлагдсан норм дүрмийг хэрэглээнд нэвтрүүлэх (Нисэх буудлын аэродромын хязгаарлалтын бүсийг тооцох аргачлал гэх мэт) | хаагчдын тоо | | | | хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээний хэлэлцүүлэгт тус байгууллагын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Э.Энхмэнд аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга болон эхний ээлжинд хамрагдах боломжтой сумдын Засаг дарга нарын хамт цахимаар оролцсон. | |
| 10 | Хаягийн системийн хэрэглээ | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 1 | - | Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас зохион байгуулсан Хаягийн системийн хэрэглээ сургалтад Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Батцэцэг 2022 оны 03 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд хамрагдсан. | 100 |
| 11 | Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийн хэрэглээ<br>*/мэргэжлийн программ хангамж /QGIS, ArcGis, AutoCad/-ийн шинэ хэрэгжүүлж байгаа бусад программийн чадавхижуулах/* | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 1 | - | Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас зохион байгуулсан Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийн хэрэглээ сэдэвт сургалтад Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Батцэцэг 2022 оны 03 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд хамрагдсан. | 100 |
| 12 | Газрын нэгдмэл сангийн тооллогын системийн хэрэглээ | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 1 | - | Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас зохион байгуулсан Газрын нэгдмэл сангийн тооллогын системийн хэрэглээ сэдэвт сургалтад Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Батцэцэг 2022 оны 03 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд хамрагдсан. | 100 |
| 13 | Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, Газар | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 1 | - | Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас 21 аймгийн Газар зохион байгуулалт, төлөвлөлт, өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнүүдийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн хэрэглээ сэдэвт сургалтад хамрагдах | | | | | чадавхижуулах, мэргэшүүлэх, ажлын гүйцэтгэл үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн хэрэглээ” сэдэвт сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд зохион байгуулсан ба уг сургалтад тус байгууллагын Газар зохион байгуулалт, төлөвлөлт, өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Т.Саранзул хамрагдсан. | |
| 14 | Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, түүнийг дагалдан гарах журам, зааврын хэрэглээ | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 1 | - | “Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, эрх зүйн акт” сэдэвт цахим сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан ба уг сургалтад архив, албан хэрэг хөтлөлтийн асуудлыг хавсран гүйцэтгэдэг Газрын төлбөр, татвар, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Болорчимэг, Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Солонго нар хамрагдсан. | 100 |
| 15 | Шинээр хөгжүүлсэн архивын программын хэрэглээ сэдэвт сургалт | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 1 | - | Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас зохион байгуулсан газрын харилцааны салбарын төрийн архивын цахим мэдээллийн сангийн цахим сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 22–ны өдөр зохион байгуулсан ба уг сургалтад архивын ажлыг хавсран гүйцэтгэдэг Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Солонго хамрагдсан. | 100 |
| 16 | Төрийн болон албаны нууцын тухай хууль, тогтоомжийн хэрэглээ | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 1 | 1 | - | Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 21 аймгийн ГХБХБГ-ын нууцын асуудал хариуцсан албан хаагчдад зориулсан цахим сургалтад Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Ж.Элбэгзаяа хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Геодезийн цэг, тэмдэгт, газар зүйн нэр, байр зүйн зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн системд өгөгдөл оруулах, засварлах | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 1 | 1 | - | Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас зохион байгуулсан Геодезийн цэг, тэмдэгт, газар зүйн нэр, байр зүйн зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн системд өгөгдөл оруулах, засварлах сэдэвт сургалтад 2022 оны 03 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Ж.Элбэгзаяа хамрагдсан. | 100 |
| 18 | Газрын мониторингийн цахим системийн хэрэглээ | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 1 | 1 | - | Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас зохион байгуулсан “Газрын мониторингийн цахим системийн хэрэглээ” сэдэвт цахим сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр, 11 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулсан танхимын сургалтад Суурь судалгаа, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Хадамдарам хамрагдсан. | 100 |
| 19 | Газрын доройтлыг тодорхойлох, зайнаас тандан судлалын аргаар газрын мониторинг хийх | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 1 | 1 | - | Газар зохон байгуулалт, геодези, зураг зүйн газраас 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр цахимаар зохион байгуулсан “Бэлчээрийн газрын мониторингийн хээрийн хэмжилт, болон зайнаас тандан судлалын аргыг боловсруулах” сэдэвт сургалтад Суурь судалгаа, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Хадамдарам хамрагдсан. | 100 |
| **Албан хаагчдад зориулсан дотоод сургалт** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | Ажлын байрны сургалтыг зохион байгуулах | Сургалт зохион байгуулсан тоо | 6 | 8 | - | Албан хаагчдын ажлын байран дээрх мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор “Мэдээллийн цаг” сургалтын арга хэмжээг 2017 оноос хойш тогтмол зохион байгуулж байна.<br>Хүний эрхийн үндэсний комиссын Дундговь аймаг дахь референт Т.Баярцэцэг “Хүний эрхийн үндсэн ойлголт”, “Жендерийн эрх тэгш байдал” сэдэвт сургалт, Төрийн албаны салбар зөвлөлөөс “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтуудыг тус байгууллагын албан хаагчдад зохион байгуулсан.<br>Энэ онд ажлын байран дээрх сургалтыг сар бүр зохион байгуулахаар төлөвлөж, 10 удаа зохион байгуулсан байна. Сургалтад хамрагдсан албан хаагчид бусад албан хаагчиддаа хамрагдсан сургалтын талаар мэдээлэл өгдөг мөн хувь хүний хөгжил, харилцаа, танин мэдэхүйн чиглэлээр сургалт зохион байгуулж, санал солилцдог.<br>Тухайлбал:<br>- “Ажлын байрны соёл буюу 5S” сургалтыг мэргэжилтэн Б.Буманбаатар 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр албан хаагчдад зохион байгуулсан.<br>- Байгууллагын ёс зүйн зөвлөлөөс Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, түүнийг ажиллах үедээ мөрдөн ажиллах тухай, ГЗБГЗЗГазраас боловсруулсан “Байгууллагын ёс зүйн дүрэм, түүнийг дагаж мөрдөх журам”-ын төслийг танилцуулсан.<br>- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Нэгдүгээрт хүүхэд” сэдэвт сургалтад тус байгууллагын 3 албан хаагч хамрагдаж дээрх сургалтын сэдвээр бусад албан | 100 |
| | | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | 16 | 16 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчиддаа мэдээлэл хийсэн. г.м | |
| 21 | Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц цаг тооцох сургалтууд | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 1 | 2 | - | Эрхэлсэн түшмэлийн багц цагийн сургалтад Газрын дарга Э.Чагнаадорж, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад Суурь судалгаа, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Хадамдарам, богино хугацааны сургалтад Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал харуицсан мэргэжилтэн Д.Баатарсүрэн, Инженерийн байгууламж хариуцсан мэрэгжилтэн Э.Дүүрэнжаргал, Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал харуицсан мэргэжилтэн Б.Буманбаатар нар цахимаар хамрагдсан. | 100 |
| 22 | Сумдын Газрын даамлуудыг чадавхижуулах сургалтыг танхимаар зохион байгуулах | Сургалтад хамрагдсан сумын Газрын даамлын тоо | 13 | 9 | БТ 0,5 | 2022 онд сумдын Газрын даамлуудын сургалтыг 3, 9 дүгээр сарuудад 2 удаа зохион байгуулсан.<br>2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс 5 хоногийн хугацаанд зохион байгуулсан сургалтаар сумдын Газрын даамлын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, албан хаагчид хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд сургалт хийж, сумдын Газрын даамлын үйл ажиллагаанд тулгарч буй асуудлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс 5 хоногийн хугацаанд зохион байгуулсан сургалтаар газар зүйн нэрийг геопорталь руу оруулж, 2003-2010 онд иргэнд өмчлүүлсэн газрын нэгж талбарын хувийн хэргийг байгууллагын архивт хүлээлгэж өгсөн. | 100 |
| 23 | Албан хаагчид хариуцсан чиг үүргийн | Сургалтад хамрагдсан албан | 13 | 13 | - | 2022 онд бусад байгууллагуудаас зохион байгуулсан 9 удаагийн сургалтад 15 албан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүрээнд төлөвлөгөөт сургалтуудад хамрагдах | хаагчдын тоо | | | | хаагч хамрагдсан байна. | |
| 24 | Албан хаагчдыг монгол бичгийн багц цагийн сургалтад хамруулах | Батламж авсан албан хаагчдын тоо | 9 | 14 | БТ 0,7 | 2021 онд байгууллагын албан хаагчийг монгол бичгийн анхан шатны сургалтад хамруулж 9 албан хаагч анхан шатны батламжаа авсан ба 2022 онд Үндэсний бичгийн дунд шатны сургалтад 16 албан хаагч (бүх албан хаагч) хамрагдаж батламжаа гардан авсан. | 100 |
| 25 | Байгууллагын соёлыг дэлгэрүүлж, төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүй, хувь хүний хөгжил, манлайлах ур чадварыг төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулах | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 27 | БТ 2.0 | Албан хаагчдын харилцаа хандлага, манлайлах ур чадварыг дээшлүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор Сэтгэл зүйч, Лектор Г.Наранбаатарын "Хандлагын үндэс ямар байна, амжилтын өндөр тийм байна" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад тус байгууллагын албан хаагчид, сумдын Газрын даамлууд (нийт 29 албан хаагчтай) бүрэн хамрагдсан. | 100 |
| 26 | Мэргэшсэн инженерийн зэрэг горилох багц цаг тооцох сургалт | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | 1 | | Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Дүүрэнжаргал мэргэшсэн инженерийн зэрэг горилох сонгон судлах "Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" сэдэвт 5 багц, Д.Баатарсүрэн нар мэргэшсэн инженерийн зэрэг горилох 3 багц цагийн сургалтад тус тус хамрагдсан. | 100 |
| 27 | Зөвлөгөөн зохион байгуулах | Зөвлөгөөнд хамрагдсан хүний тоо | - | 50 | ОНТ .... | Орон нутагт барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын захирал, инженер техникийн ажилтан, төрийн байгууллагуудын төлөөллүүд оролцсон "Барилгын салбарын ажилтны зөвлөгөөн"-ийг 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан. Тус зөвлөгөөнөөр орон нутагт хийгдэж буй бүтээн байгуулалтад аж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахуйн нэгжүүдийн оролцоо, тулгамдаж буй асуудал, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэж зөвлөмж, чиглэл өгсөн. Үүнд:<br>- Орон нутагт дутагдалтай байгаа инженер механикийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бодлогоор дэмжин нэмэгдүүлэх<br>- Орон нутаг үйлдвэрлэж буй барилгын материалыг баталгаажуулалтад хамруулан, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх гэх мэт.<br>- Барилга угсралтын ажил удаашралтай байгаа ажлуудыг эрчимжүүлэх, гэрээнд заасан хугацаанд ашиглалтад оруулах | |
| **Дундаж хувь 100** | | | | | | | |

Хэрэгжилттэй танилцсан:

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ДАРГА Э.ЧАГНААДОРЖ

Хэрэгжилт гаргасан:

ГАЗРЫН ТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭ, ТАТВАРЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.БОЛОРЧИМЭГ